

# Living the Lotus 1

*Buddhism in Everyday Life*

2025  
VOL. 232



**РКК, Оклахома салбар**

## Living the Lotus Vol. 232 (2025.01)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Хүн бүр “баян бүрд” болох нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Шинэ жил гэдэг “эхний өртөө”

Та бүхэнд шинэ оны мэнд дэвшүүлье. Бид бүхний ийнхүү хамт угтаж, нэгэн зэрэг шинээр эхлэх жилийн эхний өдрийг галт тэрэгний “эхний өртөө”-өөр зүйрлэж болно. Мөн энэ өдөр нь өнгөрсөн жилийн алдаа дутагдалдаа дүгнэлт хийн шинэ зорилт тавьж, ямар сэтгэлтэй байхаа тодорхойлох өдөр билээ. Дуучин Саитоо Мокичи (1882–1953) гуайн “Шинэ оны эхэнд, сэтгэл зүрхэндээ нэгийг бодон урагшлая” гэх дууны бадаг байдаг шиг эхний өртөө дээр бүтэн жилийн аялалынхаа бэлтгэлийг сайтар хангах хэрэгтэй. Та бүхэн энэ жил “юуг үргэлж санаж явъя” гэж шийдсэн бэ?

Миний хувьд энэ жил хий насаар 88 нас хүрэх гэж байгаадаа туйлын их баяртай байгаа ба үүнийг гүнээ талархан хүлээж авч байгаа. Насны тооноос үл хамааран өөрийгөө хөгжүүлж, урагш ахих нь хүний угийн мөн чанар гэдэг тул 88 насыг амьдралын дайрч өнгөрөх “нэг өртөө” гэж хүлээн авч, энэ толгодыг даваад дараагийн толгодыг зорин урагшилна гэж би бодож байгаа. Тийм болохоор энэ жил ч гэсэн ямагт хичээн шамдах хийгээд энэрэн нигүүлсэх сэтгэлээ марталгүй урагш ахиж, өөрийгөө хөгжүүлэх болно.

Энэ бол миний “нэг жилийн зорилт” ба ер нь үргэлж ийм байдаг. Харин сүүлийн жилүүдэд “хүн бэлдэх” гэсэн чухал асуудал толгойд бодогдох болсон.

Сансар огторгуйд хөвөх цэнхэр усан гариг болох дэлхийн байгаль орчин жилээс жилд муудаж, тэнд амьдрах хүмүүсийн хэрүүл маргаан, дайн дажин үргэлжилсээр. Эл байдлыг харахаар бид бүхэн хүний зовлон шаналалыг ойлгож мэдэрдэг хүнлэг уужуу сэтгэлтэй хүнийг өгсөн хүмүүжүүлэх “зорилт” тавих нь нэн чухал гэж бодогддог юм.



## Сэтгэл зүрхэндээ мод тарих нь

Байгууллагын 100 жилийн ойг зорин “хүн бэлдэх” үйл хэрэгт анхааръя гэж би өмнө уриалсан. Бурхны шавь бидний байр сууринаас хэлэх юм бол бурхны сургаалаар дамжуулж өөрийн жаргал төдийгүй мэдээж хэрэг гэр бүл, нутаг орныхоо хүмүүсийн төлөө, цаашлаад алс холын улсын хүн зоны аз жаргалын төлөө, тэд бүгд аврагдаасай хэмээн залбиран хамаг чадлаараа зүтгэдэг эелдэг сайхан сэтгэлтэй бодисадва хүнийг өгсөн хүмүүжүүлэх гэсэн үг юм.

Хүмүүсийг тайвшруулж, амар амгаланг мэдрүүлэх, нэг ёсондоо “баян бүрд” мэт сэтгэлийг тээсэн бодисадва хүний байгаа газар тэр чигээрээ баян бүрд болдог. Мөн тийм хүмүүс цугларах юм бол санга нарын хамтрал (сүсэг нэгт нөхөд) хэмээх баян бүрд бий болж, тэр нь хүмүүсийн сэтгэлийг зөөллөн дулаацуулах газар болон өргөжин тэлээсэй гэж би дотроо дүрслэн боддог юм. Энэ бол мэдээж хэрэг байгууллагаа томруулах гэсэн зорилго бус улс нийгэм, хүн төрөлхтөнд тулгараад буй аюул заналыг харах ахуйд төрж буй хүсэл эрмэлзэл билээ.

Эрт дээр үед Шагжамүни бурхныг хүртэл хороохыг санаархсан хүн байсан шиг хүн төрөлхтөн үүссэн цаг үеэс л аливааг өөрийнхөөрөө байлгахыг хүсэх хүсэл шунал байсаар байгаа ба шунал хүсэл, хүчирхийлэл харин ч бүр ихэссээр байна. Шунал хүсэлд хязгаар үгүй шиг “хүсэл эрмэлзэл ч гэсэн хязгааргүй байх учиртай” гэж ухаантан мэргэд сургадаг. Хүсэл эрмэлзэл байхгүй газар хөгжил дэвшил ч байхгүй ба хүний амьдрал гэдэг хүсэл мөрөөдлөө биелүүлэхийн төлөөх аялал гэж хэлдэг. Бид энэхүү аялалын гарааны эхэнд зогсож байгаа ба юуны түрүүнд өөрөө гэр бүлийнхнээ амирлуулах ус мод тэгширсэн баян бүрд болж, цаашлаад гэр бүл нь ойр тойрныхоо баян бүрд болохоос аялал эхэлнэ.

Буддизмд бусдын амь таслахыг хамгийн том нүгэл гэж үздэг. Тиймээс бид бүхэн бусдыг энэрэн хайрлах үйл хийгээд үг яриаг чухалчилж, энэрэн нигүүлсэх үйлийг хийн өдөр бүр амь насны эрхэм нандин болохыг, бүгд нэгэн бүхэл гэдгийг өөртөө сануулдаг. Энэ үйл нь бусдын төлөөх үйл бөгөөд хүмүүсийн сэтгэл зүрхэнд шинэхэн баян бүрдийг бүтээх өвс ургамалыг үрслүүлдэг. Бид ийнхүү хүмүүстэй эв нэгдэлтэй байж, талархсан сэтгэлээр амьдралын төлөө хичээх нь “ирээдүйг даатгах хойч үеэ эрхэмлэн хүндэлж буй үйл” гэж Үүсгэн байгуулагч илэрхийлсэн ба өөрөөр хэлбэл ийм амьдрал нь “ирээдүйн төлөөх өргөл хүндлэл” билээ.

“Косей” сэтгүүл, 1-р сарын дугаараас



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Нийгэмлэгийн тэмдэглэлт баяр ёслолууд

### Үүсгэн байгуулагчийн нирваанд орсон өдрийн ёслол

Үүсгэн байгуулагчийн нирваанд орсон өдрийн ёслол 10 сарын 4-нд болдог.

1999 оны энэ өдөр 92 насандаа таалал төгссөн Үүсгэн байгуулагчид хүндэтгэл үзүүлэн магтан дурсаж, талархал илэрхийлж, сургаал номыг нь залгамжлан авч амьдралдаа хэрэгжүүлэх тангараг өргөх ёслол юм.

Тэрээр Рисшо Косей Кай нийгэмлэгийг үүсгэн байгуулсан цагаас Цагаан лянхуа

судрын сургаалыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлж, хүмүүсийг зовлонгоос аврахын хамтаар шашин хоорондын хэлэлцээрээр дамжуулан даян дэлхийд энх тайвныг тогтоохын төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан. Энэхүү үйл хэрэгт хүн хүнээ хүндлэх, хүлээн зөвшөөрөх, зовлон шаналалаа хуваалцах, хамтдаа хичээх гэсэн “Нэг хөлгөний мөн чанар” агуулагддаг.



#### Бяцхан мэдлэг

Үүсгэн байгуулагч 1979 онд Темплетоны шагналыг хүртжээ. 1973 онд үүссэн энэхүү шагналыг шашны хөгжилд хувь нэмэр оруулсан хүнд олгодог ба Шашны ертөнцийн нобелийн шагнал гэгддэг.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Оэшики - Нэг хөлгөний баяр



### Бяцхан мэдлэг

Ничирэн гэгээнтэн Камакурагийн үед одоогийн Чива мужид төрсөн ба 16 настайдаа сахил хүртэж, янз бүрийн шашны номлолд суралцангаа Камакура, Хий ууланд бурхны номд суралцан бясалгасан гэдэг. Тэрбээр “Рисшо Анкокүрон” зэрэг олон ном судар бичиж, Цагаан лянхуа судрын сургаалыг түгээн дэлгэрүүлэхийн төлөө амьдралаа зориулсан хүн юм.

Жагсаалын эхэнд баярын бэлгэ тэмдэг сүр жавхланта туг явж, араас нь лимбэ, цохивор хонх, бөмбөрийг хэмнэлтэйгээр тоглож, олон мянган дэнлүүн цэцэг тэнгэрт бүжнэ.

“Оэшики” нь Ничирэн гэгээнтний таалал төгссөн өдөр (10 сарын 13) болдог дурсгалын үйл ажиллагаа, дэнлүүний ёслол юм.

Рисшо Косэй Кай нийгэмлэг нь Цагаан лянхуа судрыг түгээн дэлгэрүүлсэн Ничирэн гэгээнтэн хийгээд тус нийгэмлэгийг үүсгэн байгуулж, дэлхий дахины энх тайвны төлөө амьдралаа зориулсан Үүсгэн байгуулагчийн ач буяныг дурсан санаж, “Ач буянд талархах, Нэг зүрх сэтгэлтэй байх, Сургаалыг түгээх” гэсэн зорилгоо батжуулахад уг баярын утга учир оршино. Жил бүрийн 10-р сарын эхний ням гарагт удирдах төв болох Их ариун ордны эргэн тойронд “Оэшики-Нэг хөлгөний баяр”-ыг тэмдэглэн баярын жагсаал зохион байгуулдаг.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Санга нарын халуун дулаан  
харилцааг эрхэмлэх жил

Акагава Кэйичи

Шинэ оны мэнд хүргэе! Энэ жил та бүхний хувьд гайхалтай сайхан жил байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

Өнгөрсөн жилийн 1 сарын 1-ий өдөр Японы Ното хойгт газар хөдлөлт болж, сэтгэл хөндүүрлэм үйл явдлаар шинэ он эхэлсэн. Нэг жил өнгөрсөн хэдий ч газар хөдлөлтийн гамшгийн ул мөр арилаагүй байгаа болохоор сэтгэл зовнисоор л байна. Түүнчлэн өнгөрсөн жил НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “Дэлхийн дулаарлын үе дуусч, дэлхийн буцлах үе ирлээ.” гэж хэлсэнчлэн далайн усны хэм нэмэгдсэний улмаас цаг агаарын хэвийн бус байдлаас үүдэлтэй байгалийн гамшиг дэлхий даяар ойр ойрхон тохиолдсон жил байлаа. Хэт халууны улмаас олон хүн амь насаа алдсан гэх зүрх шимшрүүлэм мэдээг ч бас үзсэн.

Яг энэ жил л хүн төрөлхтөн туулсан зовлон шаналалаасаа олж ухаарсан мэргэн ухаанаа нэгтгэж, хүн байгаль хоорондоо эв нийцэлтэй Амар амгалан ертөнцийг бий болгохын төлөө өчүүхэн ч гэсэн алхам хийх жил болоосой гэж туйлын их хүсэж байна.

Саяхан архины хамаарлын эсрэг үйл ажиллагаа явуулдаг нэгэн байгууллагын гишүүнээс “Донтолтын эсрэг үг бол хүн хоорондын харилцаа” гэх гайхалтай үгийг сонсож билээ. Буддын шашинтнууд бидний хувьд үүнийг “санга нарын халуун дотно харилцаа автагдах сэтгэлээс ангижруулдаг” гэж хөрвүүлж болох болов уу. Нивано ерөнхийлөгчийн энэ сарын айлдварт сургасны дагуу гэгээлэг, эелдэг, халуун дулаан харилцааг бий болгодог “баян бүрд” мэт номын андуудын хүч байхад олон асуудлыг даван туулж чадна гэдэгт итгэж, 2025 оныг гурван эрднээ хүндлэн дээдлэх жил болгон хичээхээр шийдлээ.




Удирдах төвийн арга хэмжээнд оролцсон гадаад салбарын тэргүүнүүдийн хамт.  
(Хооринкаку танхим, урд эгнээний голд: Акагава хэлтсийн дарга)  
2024 оны 11 сарын 13-ны өдөр.

# Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



## 🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



X

